



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



# СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ КАНКУНЫ ЗАРЧМУУДЫГ МОНГОЛ ОРНЫ НӨХЦӨЛД НИЙЦҮҮЛЖ ТОДОРХОЙЛСОН НЬ

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд болон Сөрөг  
нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем

Бичиг баримтын төсөл

2018 оны 10 сар

### **Тайланг эрхлэн хэвлүүлсэн:**

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ). Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг Монгол орны нөхцөлд нийцүүлэн тодорхойлсон нь. Бичиг баримтын төсөл 2018 оны 10 сар.

### **Тайланг ашиглах зөвшөөрөл**

Уг тайлангийн эх сурвалжийг дурдсан тохиолдолд, урьдчилж бичгээр зөвшөөрөл авахгүйгээр сургалтын болон арилжааны бус зориулалтаар олшруулан хэвлэж болно.

Тайланд зөвхөн зохиогчдын үзэл бодлыг тусгасан бөгөөд энэ нь Монгол орны UN-REDD хөтөлбөр болон хамтран ажилладаг байгууллагуудын байр суурийг илэрхийлээгүй болно.

### **Талархал**

Уг баримт бичгийг боловсруулахад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн Монгол орны UN-REDD хөтөлбөрийн баг, СНСЗ болон СНСМС-ийг боловсруулах техникийн ажлын хэсгийн гишүүд болон СНСЗ-уудыг тодорхойлох уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон бусад оролцогчдод талархал илэрхийлье. Мөн техник, арга зүйн туслалцаа үзүүлсэн UN-REDD хөтөлбөрийн бүсийн болон олон улсын зөвлөхүүд, НҮБ-ын Байгаль орчин, дэлхийн байгаль хамгаалал, хяналтын төв (UNEP-WCMC)-д талархал илэрхийлье.

### **Холбоо барих**

Энэхүү тайлантай болон бусад холбогдох үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл авах бол Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Оюунсанаатай ([oyunsanaa@mne.gov.mn](mailto:oyunsanaa@mne.gov.mn)) холбоо барина уу.

## АГУУЛГА

Танилцуулга .....	4
СНСЗ-уудыг Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлох ажлын үйл явц ба аргачлал .....	6
Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлсон нь.....	8
<i>Хавсралт 1: Канкуны зарчмууд .....</i>	<i>23</i>
<i>Хавсралт 2: Монгол орны үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлсон сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Олон улсын санхүүгийн корпорацийн Үйл ажиллагааны стандартын зарчим, зорилго, шаардлагуудтай харьцуулж үзсэн нь .....</i>	<i>24</i>

## ТОВЧИЛСОН ҮГС

ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
ОХТ	Ойн хяналтын түвшин
ОН	Ойн нөхөрлөл
ОУСК	Олон улсын санхүүгийн Корпораци
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
БАХ	Бодлого, арга хэмжээ
БХЖ	Бодлого, хууль, журмууд
ҮАС	Үйл ажиллагааны стандарт
СНСМС	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем
СНСЗ-СНСМС ТАХ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд болон СНСМС-ийг боловсруулах техникийн ажлын хэсэг
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ХҮ	Хяналт, үнэлгээ
ҮОМС	Үндэсний ойн мониторингийн систем
ОДБ	Ойн дагалт баялаг
REDD+	Ойн хомсдол доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын бууруулахад Байгаль хамгаалал, ойн тогтвортой менежмент, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэхийн ач холбогдол
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
ОТМ	Ойн тогтвортой менежмент
UNEP-WCMC	НҮБ-ийн Байгаль орчин, дэлхийн байгаль хамгаалал, хяналтын төв
НҮБ-ын УАӨСК	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь Конвенц
UN-REDD	Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн НҮБ-ын хамтарсан санаачилга

## ТАНИЛЦУУЛГА

Энэхүү бичиг баримтын төсөлд Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг Монгол орны үндэсний нөхцөлд хэрхэн нийцүүлэн тодорхойлж, ойлгохтой холбоотой хийсэн ажлын үр дүнг танилцууллаа. НҮБҮАӨСК-ийн Талуудын дунд байгуулсан Канкуны гэрээ (Шийдвэр 1/CP.16) -нд REDD<sup>+</sup> буюу Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байгаа улс орнуудыг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад үүсч болох сөрөг нөлөөллийг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс сөрөг нөлөөллөөс сэргийлэх багц 7 зарчмыг өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд тусган, хэрэгжүүлэхийг уриалсан байна (Хавсралт 1-ийг үз).

Үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох гэдэг нь REDD<sup>+</sup>-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмууд (СНСЗ)-ыг тухайн улсын хүрээнд ямар утгаар ойлгохыг тайлбарлахыг хэлэх бөгөөд үүнд нийтээр хүлээн зөвшөөрсөн нэр томъёог ашигладаг. Мөн тухайн улсын хувьд хамгийн нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлдог. Тухайлбал, REDD<sup>+</sup>-ийн хэрэгжилтийн явцад бий болох байгаль орчин, нийгмийн үр ашгаас аль<sup>2</sup> нь тухайн улсад хамгийн чухал бөгөөд одоо хэрэгжиж байгаа бодлого, хууль, журмуудтай холбоотой болохыг тодорхойлж өгнө.

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг тодорхойлох ажлыг холбогдох талуудын оролцоотойгоор хэрэгжүүлдэг. Эндээс олон талын оролцоо эхэлж, улмаар СНСЗ-уудыг (бусад зарчмуудыг ч мөн адил) нэгдсэн байдлаар ойлгож авахад дэмжлэг болно. Канкуны зарчмуудыг тодорхойлох нь цаашид Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (СНСМС)-ийг боловсруулах ажлын гол цөмийг бүрдүүлж өгнө. НҮБҮАӨСК-ийн газарт Тайлан (SoI буюу СНСЗ-уудын хэрэгжилтийн талаарх тайлан) хүргүүлэх талаарх удирдамжид улс орнууд СНСЗ тус бүрийг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн тодорхойлох шаардлагатай гэж заасан байдаг.<sup>3</sup>

НҮБ-ын УАӨСК-ийн хүрээнд хэрэгжиж байгаа REDD<sup>+</sup> санаачилга нь Монгол улсын Засгийн газарт ойн хомсдол, доройтлыг бууруулж, байгалийн ойг хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлэх юм. Монгол Улс нь 2011 онд UN-REDD хөтөлбөрт түнш болж нэгдэн орсон бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс REDD<sup>+</sup>-д бэлтгэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний дотор ойн хомсдол, доройтлын хүчин зүйлсийг судлах; REDD<sup>+</sup> Үндэсний хөтөлбөр батлуулах; 2018 оны 1 сард ойн суурь түвшний (ОСТ) тайланг хүргүүлж, 6 сард дахин шинэчилж илгээх; үндэсний ойн мониторингийн системийг хөгжүүлэх; СНСЗ болон Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

---

<sup>1</sup> REDD<sup>+</sup> буюу ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах механизмыг НҮБ-ын УАӨСК-ийн Талууд хамтран байгуулсан. Энэ механизмын дагуу хөгжиж буй орнуудад ой бүхий газраас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үр дүнгээр нь урамшуулал олгож, нүүрстөрөгч багатай тогтвортой хөгжлийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийхэд нь дэмжлэг үзүүлэх юм. REDD<sup>+</sup> нь ойн хомсдол, доройтлоор хязгаарлагдахгүй, ой хамгаалах, ойн тогтвортой менежмент, ой дахь нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэхийн ач холбогдлыг давхар харгалзаж үздэг (<http://www.unredd.net/about/what-is-redd-plus.html>)

<sup>2</sup> REDD<sup>+</sup>-ийн гол зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэдэг боловч үүний зэрэгцээ нутгийн иргэдийн амжиргаа дээшлэх, хөрсний чанар сайжрах зэрэг экосистемийн үйлчилгээ, байгалийн нөөцийн менежменттэй холбоотой бусад үр дүн гардаг.

<sup>3</sup> Шийдвэр CP/21-ийн хянан тохиолдуулаагүй хувилбарыг доорх холбоосоос үзнэ үү ([http://unfccc.int/files/meetings/paris\\_nov\\_2015/application/pdf/sbsta\\_42\\_agenda\\_item\\_further\\_guidance\\_on\\_ensuring\\_transparency\\_cop\\_auv\\_template.pdf](http://unfccc.int/files/meetings/paris_nov_2015/application/pdf/sbsta_42_agenda_item_further_guidance_on_ensuring_transparency_cop_auv_template.pdf)).

## **Монгол Улсад СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлон хэрэгжүүлэх арга зам**

СНСЗ-уудын дагуу REDD+-ийн бодлого, арга хэмжээ (БАХ)-г хэрэгжүүлэх явцдаа тухайн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдлийг бууруулахад анхаарах ёстой гэсэн шаардлагыг олон улсын хэмжээнд тавьдаг. REDD+-ийн СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд тохируулж хэрэгжүүлэх гэдэг нь тухайн улс өөрийн улсын дотоодод дэвшүүлсэн зорилго, зорилтууд болон улс орныхоо нөхцөл байдалтай уялдуулж, одоогийн байгаа системүүдээ бүрэн ашиглах замаар олон улсын гэрээ, хэлэлцээрийг дагуу хүлээсэн үүргээ (НҮБУАӨСК болон бусад г.м)<sup>4</sup> биелүүлэхийг хэлнэ. СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох, хэрэгжүүлэх ажил нь дараах үндсэн хэсгүүдээс бүрддэг. Үүнд:

- I. СНСЗ-тай холбогдож болохуйц тухайн улсад хэрэгжиж байгаа бодлого, хууль, журмууд,
- II. СНСЗ-уудыг хэрэгжүүлэхтэй холбоотой институцийн чиг үүрэг, журам, чадавх,
- III. СНСЗ-уудыг бодлого, хууль, журамд хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг бүрдүүлэх СНСМС,
- IV. СНСЗ-уудыг бодлого, хууль, журамд хэрхэн тусгаж хэрэгжүүлж байгаа талаарх НҮБУАӨСК-д хүргүүлэх нэгдсэн тайлан зэрэг болно.<sup>5</sup>

Монгол Улс REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг боловсруулах, мөн НҮБУАӨСК-ийн шаардлагад нийцсэн СНСМС-ийг бий болгох үндэс суурийг тодорхой үе, шаттайгаар тавьсан. Эдгээрийг боловсруулахдаа одоогийн байгаа хууль, журам, институц болон мэдээллийн системд аль болох түшиглэхийг эрмэлзэж байгаа бөгөөд ингэснээр Монгол улс олон улсын СНСЗ-уудыг биелүлээд зогсохгүй үндэснийхээ зорилтуудтай тэдгээр зарчмуудыг уялдуулах боломжтой болов. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд улсын болон орон нутгийн түвшний холбогдох талуудын оролцуулсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, REDD+-ийн БАХ (бодлого, арга хэмжээ), REDD+ Үндэсний хөтөлбөр зэргийг боловсруулах үйл явцтай уялдуулсан.

Монгол улсад СНСЗ-уудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах 6 гол үе шатуудаас бүрддэг:

Алхам 1: СНСЗ-уудын зорилго, хамрах цар хүрээг эцэслэж боловсруулах

Алхам 2: REDD+-ийн БАХ-нүүдийг хэрэгжүүлэх явцад үүсэж болох үр ашиг ба эрсдэлийн үнэлгээ

Алхам 3: СНСЗ-уудтай холбоотой бодлого, хууль, журмуудыг үнэлэх, СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох

Алхам 4: СНСМС-ийн мэдээллийн хэрэгцээ, бүтцийг тодорхойлох

Алхам 5: Одоогийн байгаа мэдээллийн систем, эх үүсвэрүүдийг нягтлах

<sup>4</sup> Жишээ нь, Уур амьсгалын Ногоон сан зэрэг санхүүжүүлэгч байгууллагуудын сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим санхүүгийн механизм гэх мэт

<sup>5</sup> НҮБ-ын УАӨСК-ийн зүгээс тодорхойлж зааж өгөөгүй хэдий ч, ерөнхийдөө СНСЗ-уудыг цаасан дээр буулгаж, засаглалын бүтцийн хүрээнд тусгаж ажиллах нь зүйтэй гэж нийгээр санал нэгдсэн билээ. СНСЗ-уудыг хэрэгжүүлэх гэдгийг тэдгээр зарчмуудыг тусгасан засаглалын тодорхой бүтцийг институцын чиг үүрэг, журам, чадавхи, үйл ажиллагааны системээр дамжуулж хэрэгжүүлэх явдал мөн гэж ойлгодог. (UN-REDD Хөтөлбөр. 2016. СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж хэрэгжүүлэх тухай удирдамж).

Алхам 6: СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулах, одоогийн байгаа мэдээллийн системүүд дээр суурилах зэрэг болно.

Энэ баримт бичигт СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох ажлын явц, үр дүнг тоймлон харууллаа (Алхам 3).<sup>6</sup>

## **СНСЗ-УУДЫГ МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛД НИЙЦҮҮЛЖ ТОДОРХОЙЛОХ ҮЙЛ ЯВЦ БА АРГАЧЛАЛ**

Монгол улсад Канкуны зарчмуудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох ажлыг СНСЗ-ууд болон СНСМС-ийг боловсруулах Техникийн ажлын хэсэг (СНСЗ-СНСМС-ийн ТАХ) тэргүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд холбогдох талуудын саналыг мөн тусгаж ажилласан. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд НҮБ-ийн Байгаль орчин, дэлхийн байгаль хамгаалал, хяналтын төв (UNEP-WCMC) болон UN-REDD хөтөлбөрийн бүсийн болон олон улсын зөвлөхүүдээс бүрдсэн баг техникийн туслалцаа үзүүлж ажиллалаа.

2017 оны 9 сард<sup>7</sup> зохиогдсон СНСЗ болон СНСМС-ийг боловсруулах ажлын хэсгийн гишүүд болон холбогдох оролцогч талуудыг оролцуулсан зөвлөлдөх уулзалтаар СНСЗ-уудыг үндэсний хэмжээнд тодорхойлох зорилго, загварыг (нэмэлт текст бүхий хүснэгт хэлбэртэй байхаар сонгосон) тодорхойлсон. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын зорилгыг үндэсний хэмжээнд дараах байдлаар томъёолохоор санал болгосон байна. Үүнд:

- БХЖ-уудыг үнэлэх, БХЖ болон тэдгээрийн хяналт, хэрэгжилтийг сайжруулах,
- БАХ-нүүдийг үнэлэх ба сонгох,
- Санхүүжүүлэгч байгууллагын тавьсан шаардлага болон хөрөнгө босгохтой холбоотой бусад шаардлагуудыг хангах,
- СНСМС-ийн загварыг тодорхойлох болон түүний хяналт, үнэлгээний системийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох ажлыг чиглүүлэхэд ашиглах маягыг 2016-2017<sup>8</sup> оны хооронд хэрэгжүүлсэн REDD+-ийн үр ашиг, эрсдэлийг үнэлэх ажлын үр дүн болон Монгол оронд мөрдөж байгаа, СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ын үнэлгээний үр дүнтэй уялдуулж боловсрууллаа. Уг маягтад (жишээг дор үзүүлэв) дээрх ажлын хэсгийн өмнө хэрэгжүүлсэн ажлууд болох эрсдэл, үр ашгийн үнэлгээ, БХЖ-ын<sup>9</sup> үнэлгээний үр дүнг СНСЗ-уудын тохирох элемент бүрт харгалзуулан оруулсан.

Үүний дараа буюу 2017 оны 12 сард зохион байгуулсан олон талын оролцоог хангасан семинарт СНСЗ болон СНСМС-ийн техникийн ажлын хэсгийн гишүүд, төрийн байгууллага, шинжлэх ухааны байгууллага, олон нийтийн болон иргэний нийгмийн байгууллагын (ИНБ) төлөөлөгч нар хамтран оролцож, өмнө хийсэн эрсдэл, үр ашгийн үнэлгээний үр дүн, БХЖ-ын

6 Монгол улсад СНСЗ-уудыг тодорхойлж хэрэгжүүлэхгэй холбоотой баримт бичгүүдийг дараах холбоосоор орж үзнэ үү. <http://www.unredd.net/announcements-and-news/2592-safeguards-country-resource-hub.html>

7 Монгол улсын REDD+-ийн СНСЗ болон СНСМС-ийн ажлын хэсгийн 3-р уулзалт, 2017 оны 9 сар. (Уулзалтын тайлан: Англи, Монгол хэлээр)

8 Монгол улсын REDD+-ийн үр ашиг, эрсдэлийн үнэлгээ, 2017 оны 8 сар. (Суурь тайлан: Англи, Монгол хэлээр; Үнэлгээний хүснэгт: Англи, Монгол хэлээр)

9 Эдгээр материал болон СНСЗ-уудыг Монгол орны нөхцөлд нийцүүлж тодорхойлсон ажлын тухай баримт бичгүүдийг дараах холбоосоор орж үзнэ үү: [at: http://www.unredd.net/announcements-and-news/2592-safeguards-country-resource-hub.html](http://www.unredd.net/announcements-and-news/2592-safeguards-country-resource-hub.html)

үнэлгээнээс гарсан мэдээллийг хянан үзэж дараа нь олон улсын хэмжээнд тодорхойлсон СНСЗ-ын элементүүдээс нэн тэргүүн Монголд хамаатай гэснийг нь сонгон тодорхойлоод, Монгол улсад СНСЗ-ийн элементүүдийг боловсруулахтай холбоотой саналаа өгсөн байна.

Дээрх семинарын үеэр гарсан саналыг үндэслэн олон улсын зөвлөх ажилтнуудаас бүрдсэн багийг томилон ажиллуулж, СНСЗ-уудыг үндэсний хэмжээнд тодорхойлсон баримт бичгийн эхний төслийг боловсруулах ажлыг зохион байгуулав. Энэхүү баримт бичгийн төслийг 2018 оны 3 сард зохион байгуулсан СНСЗ ба СНСМС-ийн Техникийн ажлын хэсгийн семинарын үеэр нягталж үзээд, тодорхой өөрчлөлт оруулж шинэчилсэн. СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлох ажлыг чиглүүлэхэд зориулж, СНСЗ-уудыг тодруулах, үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлохтой холбоотой мэдээллийг цуглуулж авах тусгай хүснэгтүүдийг боловсруулав. Тэдгээр нь доорх үзүүлсэн 1-р хүснэгтийн загварт суурилсан болно. Мөн энэ хүснэгтэд СНСЗ-уудын элемент тус бүрийн тодорхойлолт, холбогдох эрсдэл, үр ашгийн талаарх мэдээлэл, СНСЗ-уудыг хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ын талаарх мэдээлэл болон хууль, журмын хэрэгжилтийн хийдэл болон цаашид сайжруулахтай холбоотой асуудлуудыг оруулсан. СНСЗ-уудыг тодорхойлсон хүснэгтүүд урт бөгөөд одоогоор хараахан эцэслэгдээгүй, боловсруулах шатандаа явж байгаа тул энэ тайланд бүрэн эхээр нь хавсаргаагүй болно.

Монгол улсад СНСЗ-уудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлсон баримт бичгийн сүүлийн төслийг дээрх бүрэн хэмжээний хүснэгтээс хураангуйлан авч энэ тайланд оруулан, 2018 оны 5-9 сар хүртэлх хугацаанд талуудад илгээж саналыг нь авсан болно. Оролцогч талуудын өгсөн саналыг бичиг баримтын эцсийн хувилбарт оруулсан. Ажлын хэсэг энэхүү баримт бичгийн эцсийн хувилбарыг бэлтгэх явцдаа REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК)-ийн зарчмуудтай хүснэгтийн аргаар харьцуулж үзээд Монгол Улсад ойн салбарын болоод уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээрх санаачилгуудыг хэрэгжүүлэхэд санхүүжилт олгох сонирхол бүхий хандивлагчдын зүгээс тавьдаг зарчмын шаардлагуудтай хэр нийцэж байгааг тогтоохоор ажиллаж байна. Хураангуйг Хавсралт 2-т үзүүлэв.

*Хүснэгт 1: СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлоход ашигласан хүснэгт*

Олон улсын хэмжээнд тодорхойлсон СНСЗ-ийн гол агуулга, элемент	Хүүрнэсэн текст тайлбар/ СНСЗ-тай холбоотой, Монгол улсын хэмжээнд тулгамдаж байгаа гол асуудлууд	Үндэсний хэмжээнд тодорхойлсон элемент	Гол үр ашиг, эрсдэл	СНСЗ-уудыг тусгах, хэрэгжүүлэхтэй холбоотой гол БХЖ-ууд	Сайжруулбал зохих зүйлс	Санал, асуулт
Үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлбол зохих гол бүрэлдэхүүн хэсэг буюу элементүүд (2017 оны 12 сард эрэмбэлсэн байдлаар)	Зөвлөх уулзалтуудаас тодорхойлсон		Монгол Улсад хэрэгжүүлэхээр санал болгож буй REDD+ бодлого, арга хэмжээнүүдийн үр ашиг, эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан.	СНСЗ-уудыг тусгах, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-ын үнэлгээнд суурилсан	БХЖ-ийн хүрээнд СНСЗ-уудыг тусгах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор юуг сайжруулах шаардлагатайг бичих	

## СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ КАНКУНЫ ЗАРЧМУУДЫГ

### МОНГОЛ ОРНЫ НӨХЦӨЛД НИЙЦҮҮЛЖ ТОДОРХОЙЛСОН НЬ

Дараах хүснэгтэд сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг Монгол Улсын нөхцөлд нийцүүлж тодорхойлсон тодорхойлолт болон эдгээр зарчмыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ-уудыг нэгтгэн харуулав. СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлсон бүрэн мэдээллийг, СНСЗ тус бүртэй холбоотой үр ашиг, эрсдэл болон БХЖ-ын үнэлгээний тайлбар, цаашид сайжруулсан саналуудтай хамт эксел хүснэгтийг Монгол орны UN-REDD хөтөлбөрөөс бэлтгэсэн.

<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим А: Тухайн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна</b>	
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b>	<b>Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ</b>
<b>A1. REDD+ Бодлого, арга хэмжээнүүд нь (БАХ) Байгаль орчныг хамгаалах талаар олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэг амлалтуудад нийцсэн, үндэсний хэмжээнд мөрдөж байгаа биологийн олон янз байдлыг хамгаалах бодлогод хувь нэмэр оруулна. Үүнд: РАМСАРЫН Конвенц, Ус хамгаалах үндэсний хөтөлбөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах Конвенц, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Ойн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх тухай Санкт Петербургийн тунхаг.</b>	Рамсарын Конвенц (1971) (Монгол улсад 1998 онд хүчин төгөлдөр болсон); Усны тухай хууль (2012) Ус үндэсний хөтөлбөр (2016-2021) / Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө Биологийн олон янз байдлын тухай Конвенц (1993) Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025) Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998) НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц (1994) Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020) Ойн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх тухай Санкт Петербургийн тунхаг (2005)



<p><b>A2. REDD+-ийн БАХ-нүүд нь Төрөөс ойн талаар баримтлах бодлого, Ойн тухай хууль, Ойн цэвэрлэгээ хөтөлбөр, Ногоон хөгжлийн бодлого болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн байна.</b></p>	<p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)  Ойн тухай хууль (2012)  Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)  Ногоон хөгжлийн бодлого (2014)  Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (1995)</p>
<p><b>A3. REDD+-ийн БАХ-нүүд нь МУ-ын Засгийн газраас ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн хэтийн төлөв 2030 болон, олон улсын тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн байна.</b></p>	<p>Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, стратеги (1993 )  Монголын Улсын тогтвортой хөгжлийн хэтийн төлөв 2030  Олон улсын тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)  Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)  Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) /Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)  Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)  Ногоон хөгжлийн бодлого (2014)</p>
<p><b>A4. REDD+ БАХ-нүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт, хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүд болох Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, НҮБ/УАӨСК-ийг хэрэгжүүлэхэд оруулах Үндэсний хувь нэмэрт тусгагдсан холбогдох зорилго/ зорилттой нийцсэн байна.</b></p>	<p>Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2017-2021)  Монгол Улсын Анхны үндэсний зорилтот хувь нэмэр (2016)  Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)  Ойн тухай хууль (2012)</p>
<p><b>A5. REDD+ БАХ-нүүд нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаг, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн тухай Конвенц болон Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого зэрэг хүний эрх, иргэдийн амьжиргааг</b></p>	<p>Монгол улсын үндсэн хууль (1992/2001)  Хүний эрхийн түгээмэл тунхаг (1948)  Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль (2000)</p>

<p><b>дэмжих талаар хүлээсэн үүрэг амлалт, бодлогод нийцсэн байна.</b></p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийн тухай олон улсын Конвенц (ОУ-ын Хөдөлмөрийн байгууллагын конвенцууд)</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлого (2016)</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)</p> <p>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын гэрээ (1966)</p> <p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээ (1966)</p> <p>Хүүхдийн эрхийн тухай Конвенц (1989)</p> <p>Хөдөлмөрийн тухай хууль (1999)</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)</p>
--	--

**Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим В: Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх**

<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон нь</b></p>	<p><b>Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ</b></p>
<p><b>В1. REDD+ БАХ-нүүдийг холбогдох БХЖ-ийн заалтуудад нийцүүлж хэрэгжүүлж, хяналт тавина. REDD+ Үндэсний Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд нэг удаа талуудын оролцоотойгоор хянана.</b></p>	<p>Захиргааны ерөнхий хууль (2015)</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, журам (2015)</p> <p>Зөрчлийн тухай хууль (2017)</p> <p>Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003)</p> <p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)</p>

<p><b>В2. REDD+-ийн БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ шаардлагатай боловсон хүчин, техникийн нөөцийг хуваарилж, Ойн тухай хуулийн хүрээнд боловсруулсан ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой институцийн болон техникийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг багтаасан байна.</b></p>	<p>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (2012)  Ойн тухай хууль (2012)  Төрийн албаны тухай хууль (2002)  Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)  Ногоон хөгжлийн бодлого (2014)  Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)  Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)</p>
<p><b>В3. Үндэсний REDD+-ийн БАХ-нүүд нь зөрчил, авлигын эрсдэлийг бууруулах, мөн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлыг хариуцсан талуудын үүрэг, хариуцлагыг холбогдох БХЖ (Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль, Төсвийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль)-уудад заасны дагуу тодорхойлж, тэдгээр хууль, тогтоомжийг мөрдөнө.</b></p>	<p>Авлигын эсрэг хууль (2006)  Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)  Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)  Төрийн албаны тухай хууль (2002)</p>
<p><b>В4. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж хэрэгжүүлэхдээ ил тод, үр дүнтэй ойн сайн засаглалыг дэмжихэд чиглэсэн үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлого, зохицуулалтууд, холбогдох хэрэгжүүлэгч байгууллагууд салбар хоорондын уялдаа холбоог хангасан байна.</b></p>	<p>Захиргааны ерөнхий хууль (2015)  Ойн тухай хууль (2012)  Газрын тухай хууль (2002)</p>
<p><b>В5. REDD+ БАХ-ын боловсруулж хэрэгжүүлэхдээ жендерийн тэгш байдлыг дэмжиж, Жендерийн тэгш</b></p>	<p>Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)  Монгол Улсын тогтвортой хөгжлийн хэтийн төлөв- 2030</p>

<p><b>байдлыг дэмжих тухай хуулийн шаардлагыг хангасан байна.</b></p>	<p>Жендерийн тэгш байдлыг дэмжих тухай хууль (2011)          Жендерийн тэгш байдлын үндэсний хөтөлбөр (2017-2021)          Байгаль орчны салбарын жендерийн стратеги (2014-2030)          Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1980)</p>
<p><b>В6. REDD+ БАХ-г Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудтай нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх ба БАХ-нүүдийн талаарх мэдээлэл ил тод, хүртээмжтэй байх бөгөөд холбогдох талуудад мэдээллийг тохирох аргаар хүргэнэ.</b></p>	<p>Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011)          Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)          Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003 )          Ажил эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)</p>

<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим С: Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн Тунхагийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх</b></p>	
<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон нь</b></p>	<p><b>Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ</b></p>
<p><b>С1. REDD+-ийг хэрэгжүүлэхдээ нутгийн иргэд болон угсаатны цөөнх гэдгийг холбогдох БХЖ-д зааснаар тодорхойлж авч үзэх ба байгалийн нөөцийг бие даан захирах эрхийг хамруулж ойлгоно.</b></p>	<p>Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)          Захиргааны ерөнхий хууль (2016)          Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003 )          Иргэдийн төлөөлөгчдийн хурал</p>

<p><b>C2. REDD+ БАХ-нүүд нь нүүрстөрөгчийг бууруулснаас ирэх үр өгөөж болон экосистемийн үйлчилгээг сайжруулсантай холбоотой үр ашгийг зохих ёсоор, тэгш хүртгээх зарчмаар хэрэгжиж, REDD+-ийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. REDD+ БАХ-нүүдийн хүрээнд урамшуулах, үр ашгийг хуваарилахад одоогийн хэрэгжиж байгаа журам, бүтцийг (нөхөрлөл, орон нутгийг хөгжүүлэх сан г.м) ашиглана.</b></p>	<p>Ойн тухай хууль (2012)  Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)  Төсвийн тухай хууль (2011)  Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)  Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)  Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль (2007)  Жендэрийн тэгш байдлыг дэмжих тухай хууль (2011)</p>
<p><b>C3. REDD+-ийг боловсруулах, хэрэгжүүлэхдээ оролцогч талуудын газар болон байгалийн нөөц ашиглах эрхийг нь зохицуулсан БХЖ-уудтай нийцүүлнэ. Мөн REDD+-ийн БАХ-нүүд нь Газрын тухай хуулиар зохицуулагдах харилцааг илүү ойлгомжтой бөгөөд тодорхой болгож өгсөн байна.</b></p>	<p>Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)  Газрын тухай хууль (2002)  Ойн тухай хууль (2012)  Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)  Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)  Усны тухай хууль (2012)  Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)</p>
<p><b>C4. REDD+ БАХ-нүүдийг нутгийн иргэд эсвэл үндэстний цөөнхийн эзэмшлийн уламжлалт мэдлэг, өв соёл болон оюуны мэдлэг, хөрөнгийг хамгаалах буюу дэмжихэд чиглэсэн холбогдох БХЖ-уудын (Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль) зүйл, заалтуудтай нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ. Нутгийн иргэдийн эзэмшлийн соёлын биет өвийг төр, шашны болон олон</b></p>	<p>Монгол Улсын үндсэн хууль (1992/2001/2013)  Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014)  Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)  Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)  Байгалийн ургамлын тухай хууль (1995)</p>

<p>нийтийн байгууллагаас тогтоосон нөхцөлийн дагуу хамгаална.</p>	<p>Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2017-2021) Генетикийн нөөцийн тухай хууль (БОАЖЯ боловсруулж байгаа)</p>
<p><b>C5. Үндэсний REDD+-ийн БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ тухайн газар болон байгалийн нөөцийг эзэмших эрхтэй иргэдийг нүүлгэн суурьшуулах болон/эсвэл эдийн засгийн үйл ажиллагааны зорилгоор нүүлгэх шаардлагатай болсонтой холбоотой үүсэх аливаа эрсдэлээс зайлсхийсэн буюу эрсдэлийн бууруулахад анхаарсан байна. REDD+ БАХ-г хэрэгжүүлэхээс өмнө нутгийн иргэдийг албан шахалтаар нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд зохих хэлбэрийн нөхөн төлбөрийг санал болгож, зөвшилцсөн байна.</b></p>	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012) Газрын тухай хууль (2002) Ойн тухай хууль (2012)</p>

<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим D: Оролцогч талууд, тухайлбал, нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах;</b></p>	
<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон нь</b></p>	<p><b>Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ</b></p>
<p><b>D1. REDD+-ийн БАХ-нүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад оролцох талуудыг тодорхойлсон байна. Тухайн БАХ-нээс хамаараад оролцогч талууд гэдэгт орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, ТХНЗ, усны сав газар, нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллага, холбоо, малчид, аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн бусад байгууллагыг хамруулна. Тухайн төлөөлөн оролцогч талууд нь зохих</b></p>	<p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015) Ойн тухай хууль (2012) Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014) Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)</p>

<p>ёсны төлөөлөл байж чадах эсэхийг холбогдох хууль, журмын дагуу тогтооно.</p>	<p>Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль (2005)</p>
<p><b>D2. REDD+ БАХ-нүүдийг тодорхойлох болон хэрэгжүүлэх явцад холбогдох оролцогч талууд нь санал болгож буй БАХ-нүүдийн талаар мэдээлэл авах, зөвлөлдөх, шийдвэр гаргахад оролцох эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, холбогдох хууль журмын дагуу хэрэгжүүлнэ. REDD+-ийн төлөвлөгөө болон хэрэгжилттэй холбоотой шийдвэр нь гаргах үйл явц нь: (i) холбогдох нотолгоо, мэдлэгт суурилсан; (ii) төр, иргэний нийгэм, олон нийт болон бусад талуудын нээлттэй хэлэлцүүлэгт үндэслэсэн; (iii) дээрх талуудын өгсөн саналыг харгалзсан байна.</b></p>	<p>Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хууль (2011)  Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2016)  Захиргааны ерөнхий хууль (2015)  Зөрчлийн тухай хууль (2017)  Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)  Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)  Ойн тухай хууль (2012)  Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)</p>
<p><b>D3. REDD+-ийн БАХ-нүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ холбогдох үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулсан байх ба салбар дундын болон олон талын хамтын ажиллагааны механизмуудыг ашиглан REDD+ БАХ-нүүдийг хэрэгжүүлж хяналт тавина.</b></p>	<p>REDD+-ийн хүрээнд бий болсон механизмууд (Жишээлбэл: Ойн тогтвортой хөгжлийн зөвлөл)  Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)  Иргэдийн төлөөлөгчдийн хурал  Ойн тухай хууль (2012)  Ойн цэвэрлэгээ хөтөлбөр(2014)</p>

<p><b>D4. МУ-ын Засгийн газар нь REDD+ийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн улмаас эрх нь зөрчигдсөн гэх иргэд болон талуудад холбогдох БХЖ-ын дагуу санал гомдлоо шийдвэрлүүлэх эрхийг нь хангаж, гомдол, санал барагдуулах зохистой, ил тод механизмыг бүрдүүлж өгсөн байна.</b></p>	<p>Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмын тухай хууль (2016)</p> <p>Төрийн байгууллага болон албан тушаалтнуудад иргэдээс ирүүлсэн гомдол саналыг шийдвэрлэх тухай хууль (1995)</p> <p>Монгол Улсын Хүний эрхийн комиссын тухай хууль (2000)</p> <p>Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003)</p>
---	---

**СНСЗ Е: Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим Е: Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашигладаг байх.**

<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b></p>	<p><b>Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ</b></p>
<p><b>E1. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойн талаарх улсын хэмжээнд мөрдөж байгаа албан ёсны тодорхойлолтод суурилсан, түүнд нийцсэн байна.</b></p>	<p>Ойн тухай хууль (2012)</p> <p>Ойн хяналтын түвшин (ОХТ)</p> <p>Ойн тооллогын удирдамж (2014)</p>
<p><b>E2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ ойн сан бүхий болон ойгоос бусад газар нутгийн аль алинд нь учрах нөлөөллийг үнэлэхтэй холбоотой хууль эрх зүйн шаардлагыг бүрэн хангасан байна.</b></p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)</p> <p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)</p> <p>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)</p>
<p><b>E3. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойг хамгаалах, хадгалах явдлыг урамшуулах, ой ашиглагчдын хариуцлагыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг илүү</b></p>	<p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)</p> <p>Ногоон хөгжлийн бодлого (2014)</p> <p>Ойн тухай хууль (2012)</p>



<p>сонгон хэрэгжүүлж, байгалийн ойг доройтуулахаас зайлсхийх буюу эрсдэлийг бууруулна.</p>	<p>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр (2014)</p> <p>Ойн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, үнэлэх, тарьсан модыг худалдаж авах тухай журам (Байгаль орчин ногоон хөгжлийн сайд болон сангийн сайдын хамтарсан тушаал 2013)</p> <p>Ургамал хамгааллын тухай хууль (2007)</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)</p> <p>Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)</p> <p><i>(Үр ашиг хуваарилахтай холбоотой с2 элементийг үзнэ үү.)</i></p>
<p><b>E4. REDD+-ийн үйл ажиллагааг байгалийн ойг таримал ой болгон хувиргах буюу бусад зориулалтаар өөрчлөхөд ашиглахгүй, ийнхүү хувиргахыг дэмжихгүй байх</b></p>	<p>Ойн тухай хууль (2012)</p> <p>Газрын тухай хууль (2002)</p> <p>Хувиргасан амьд организмын тухай хууль (2007)</p> <p><i>(Байгалийн ойн талаарх тодорхойлолтыг E1 элементээс үзнэ үү.)</i></p>
<p><b>E5. REDD+-ийн үйл ажиллагааг боловсруулах, эрэмбэлж, хэрэгжүүлэхдээ нийгмийн сөрөг нөлөө учруулахаас зайлсхийж, эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдал, үр ашгийг дэмжиж, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст ажил эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх талаар онцгой анхаарал хандуулна.</b></p>	<p>Уур амьсгалын өөрчлөлтийн тухай үндэсний хөтөлбөр (2011)</p> <p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)</p> <p>Ногоон хөгжлийн бодлого (2014)</p> <p>Ойн тухай хууль (2012)</p> <p>Газрын тухай хууль (2002)</p> <p>Ойн цэвэрлэгээ хөтөлбөр(2014)</p> <p>Ажил эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)</p>

	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)</p> <p>Аялал жуулчлалын тухай хууль (2000) / Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2016-2020)</p> <p>Монгол мал үндэсний хөтөлбөр (2016)</p> <p>Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)</p> <p><i>(Ядуурлыг бууруулах тухай АЗ , Эдийн засгийн үйл ажиллагаа явуулах шаардлагаар нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлаарх С5-аас тус тус харна уу.)</i></p>
<p><b>Е6. REDD+ БАХ-нүүд оролцогч талуудтай орон нутгийн болон үндэсний хэмжээнд зөвлөлдсөний үндсэн дээр хамгаалалтын ач холбогдол өндөртэй ойг тодорхойлж, тэдгээрийн экосистемийн үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээхэд тусална.</b></p>	<p>Ойн тухай хууль (2012)</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)</p> <p>Ойн тухай хууль (2012)</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994) / Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)</p> <p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)</p> <p>Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)</p>

**Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим F: Үр дүн хувирах эрсдэлийг тооцох<sup>10</sup>**

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент	Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ
<p><b>F1. REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох болон хэрэгжүүлж, хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+-ийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна.</b></p>	<p>Ойн тухай хууль (2012)  Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)  Ногоон хөгжлийн бодлого (2014)  Газрын тухай хууль (2002)  Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012) / Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020)  Ургамал хамгаалах тухай хууль (2007)  Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)  <i>(Эрсдэлт хүчин зүйлсийн талаар F1 элементийг үзнэ үү.)</i></p>
<p><b>F2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөж болох эрсдэлүүдийг харгалзаж үзсэн байна. Эдгээр эрсдэлд (хуулийн, нийгэм, экологийн хүчин зүйлс буюу бодлого өөрчлөгдөж, ойн нөөцийн хэт ашиглалт нэмэгдэх г.м) дүн шинжилгээ хийсний үндсэн дээр, REDD+ БАХ-нүүдийг боловсруулж,</b></p>	<p>Ойн тухай хууль (2012)  Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)  Ногоон хөгжлийн бодлого (2014)  Газрын тухай хууль (2002)  Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)</p>

<sup>10</sup> Энэ сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын хүрээнд ашиглаж байгаа “Үр дүн хувирах” гэдэг нэр томъёо нь REDD+ -тэй холбоотой бөгөөд хүлэмжийн хийн ялгарал буурсан, бий болсон амжилт, үр дүн тогтвортой бус, хэзээ нэг цагт өөрчлөгдөж болно гэсэн утгатай юм.

<sup>11</sup> REDD+-ийг хэрэгжүүлж байгаа орнууд нь хүлэмжийн хийн ялгарлын талаар үнэн бодитой мэдээлэл өгөх мониторингийн системтэй байх шаардлагатай бөгөөд НҮБ/УАӨСК-ийн Талуудын 16 дугаар бага хурлын Шийдвэрт заасны дагуу Үндэсний ойн мониторингийн систем (YOMS) байгуулсан байна.

<p>хэрэгжүүлэхдээ үр дүн хувирах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгасан байна.</p>	<p>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020)          Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль(2012)          Төрийн албаны тухай хууль (2002)          Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам (2016)          Ойн болон хээрийн түймрээс сэргийлэх тухай журам (ЗГ-ын 2013 оны шийдвэр No. 109)          Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)</p>
<p><b>F3. Үндэсний ойн мониторингийн систем (YOMC)<sup>11</sup>-ийг боловсруулж, сайжруулан ашиглахдаа хөтөлбөрийн үр дүн хувирч, өөрчлөгдөж байгаа талаар болон өмнө тодорхойлсон эрсдлүүдтэй холбоотой мэдээллийг илрүүлэх давтамж, тохиргоог хийж өгсөн байна. Үүнийг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадавхийг бүрдүүлсэн байна.</b></p>	<p>YOMC-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө/ Төвлөрсөн ойн мэдээллийн системийг ажиллуулах стандарт (SOPs).</p>
<p><b>F4. Аливаа үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөх тохиолдол гарсан үед түүний шалтгааныг судалж, зохих менежментийн арга хэмжээ авч байх механизмыг REDD+-ийн хяналт, үнэлгээний системд суулгаж өгсөн байна.</b></p>	<p>Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003)          Үндэсний REDD+ хөтөлбөр, хяналт, үнэлгээний систем, YOMC-ийн зарим үйл ажиллагаа, протоколтой холбоотой бусад бичиг баримтууд</p>

**Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим G: Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах<sup>12</sup>**

Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент	Тухайн СНСЗ-ыг тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой БХЖ
<p><b>G1. Монгол орны REDD+ Хөтөлбөр болон үүний гол хэсэг болох REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа улсын нийт нутаг дэвсгэрийг аль болох зохих ёсоор хамруулах (ойн болон ой бус экосистемүүдийг оруулах г.м) ба REDD+-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах шаардлагатай салбар дундын талуудын оролцоог багтаасан байна.</b></p>	<p>Монгол орны REDD+ хөтөлбөр болон Ойгоос ялгарах хүлэмжийн хийн хяналтын түвшин.</p> <p>Ойн тухай хууль (2012)</p> <p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)</p> <p>Газрын тухай хууль (2002)</p> <p>Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)</p> <p>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020)</p>
<p><b>G2. REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох, хэрэгжүүлэх болон хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+-ийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна.</b></p>	<p>Ойн тухай хууль (2012)</p> <p>Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015)</p> <p>Газрын тухай хууль (2002)</p> <p>Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль (2012)</p> <p>Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020)</p> <p>Ургамал хамгаалах тухай хууль (2007)</p> <p><i>(Сөрөг хүчин зүйлсийг авч үзэх тухай F2 элементээс харна уу.)</i></p>

<sup>12</sup> “Шилжих” буюу өөр газарт тархах гэдэг нэр томъёо нь тодорхой ой бүхий талбайг хамгаалж, ойн доройтол, хомсдлын хүчин зүйлсийг бууруулах явцад тэдгээр хүчин зүйл өөр газарт тархах буюу шилжихийг хэлнэ.

<p><b>G3. REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсний улмаас сөрөг нөлөө нь ойн болон ойн бус өөр газарт шилжих эрсдэл үүсэж, ой түшиглэж амьдардаг болон бусад төрлийн аж ахуй эрхэлдэг иргэдийн амьжиргаанд нөлөөлөх эрсдэл үүсэж болохыг харгалзан үзсэн байна. Эдгээр эрсдэлийг шинжилж үзсэний үндсэн дээр тэдгээрийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг БАХ-нүүдэд тусгасан байна.</b></p>	<p>Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)  Ойн тухай хууль (2012)  Ногоон хөгжлийн бодлого (2014)  Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994)  Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997)  Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам (2016)  <i>(Үр дүн хувирах эрсдэлийн талаар F1-ийг , эдийн засгийн үйл ажиллагаа явуулах зорилгоор нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлын талаар C5 элементийг үзнэ үү.)</i></p>
<p><b>G4. REDD+-ийн үйл ажиллагааг хянах, үнэлэх системд хүлэмжийн хийн ялгаралт буурсан үр дүн хожим хувирах, ялгаралт ой, ойн бус өөр газарт шилжиж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, шалтгааныг олж тогтоох давтамжийг тохируулж өгсөн байх ба үүнийг гүйцэтгэхэд шаардагдах боловсон хүчний болон техникийн нөөцийг шийдэж өгсөн байна.</b></p>	<p>YOMC-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө/ Төвлөрсөн ойн мэдээллийн системийг ажиллуулах стандарт (SOPs).  (YOMC-ийн талаар CHC3 F3-ыг үз)</p>
<p><b>G5. REDD+-ийн үйл ажиллагааг хянах, үнэлэх системд хүлэмжийн хийн ялгаралт ой, ойн бус өөр газарт шилжиж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, сөрөг нөлөө шилжиж байгаагийн цаад шалтгааныг олж тогтоон, зохих менежментийн арга хэмжээг авч байх механизмыг суулгаж өгсөн байна.</b></p>	<p>Төрийн хяналт, шалгалтын тухай хууль (2003)  Үндэсний REDD+ хөтөлбөр, хяналт, үнэлгээний систем, YOMC-ийн зарим үйл ажиллагаа, протоколтой холбоотой бусад бичиг баримтууд</p>

### **Хавсралт 1: Канкуны зарчмууд**

[REDD+] –ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг дэмжиж, мөрдөх нь зүйтэй.

(a) Тухайн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна;

(b) Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх;

(c) Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхагийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх;

(d) Оролцогч талууд, тухайлбал, нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах;

(e) Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг\* сайжруулахад ашигладаг байх \*

(f) Үр дүн хувирах эрсдэлийг тооцох;

(g) Хүлэмжийн хийн өөр газарт шилжих<sup>13</sup> явдлыг бууруулах

*\* Уугуул иргэдийн тухай НҮБ-ын Тунхаг, “Олон улсын эх дэлхийн өдөр”-ийн баримт бичигт уугуул иргэд, орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааны хэрэгцээ болон ихэнх улсад нутгийн уугуул иргэдийн амьжиргаа ойгоос хамааралтай байдаг талаар тусгасан байгааг харгалзан үзэх*

---

<sup>13</sup> НҮБУАӨСК-ийн Талуудын 16 дугаар бага хурлын Шийдвэр -1, хавсралт 1, хэсэг 2

**Хавсралт 2: Монгол орны үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлсон сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг Олон улсын санхүүгийн корпорацийн Үйл ажиллагааны стандартын зарчим, зорилго, шаардлагуудтай харьцуулж үзсэн нь**

Дараах хүснэгтэд Монгол орны үндэсний нөхцөлд нийцүүлж тодорхойлсон сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмын элементүүдийг Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Уур амьсгалын ногоон сангаас (УАНС) баталсан байгаль, орчин нийгмийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр баримтлах байгаль орчин, нийгмийн салбарын үйл ажиллагааны гүйцэтгэлийн стандартуудтай “харьцуулсан зураглал”-ыг харуулав. Олон улсын санхүүгийн Корпорацийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлж байгаа хувийн хэвшлийн байгууллагууд үйл ажиллагааны стандарт (ҮАС) хэмээх 8 зарчим бүхий стандартыг мөрдөх ёстой ажээ. Уг стандартын хүрээнд, төсөл хэрэгжүүлж байгаа байгууллагууд нь байгаль орчин, нийгмийн менежментийн системтэй болсон байх ёстой гэсэн шаардлага тавьдаг бөгөөд эдгээр стандартууд дээрх шаардлагад суурилсан байна. Тэдгээр стандартын зарчмуудыг REDD+-ийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа оронд шууд хуулан авч хэрэгжүүлэхэд амаргүй. Хэдий тийм боловч ингэж харьцуулж үзэх нь угтаа Монгол орны үндэсний сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын элементүүд нь дээрх байгаль орчны үйл ажиллагааны гүйцэтгэлийн стандартуудтай хэр нийцэж байгааг тогтоох зорилготой юм. (Харьцуулсан хүснэгтийг бүрэн эхээр нь авахыг хүсвэл бидэнд хандаарай.)

<b>Зарчим А: [REDD+] –ийн үйл ажиллагаа нь ойн үндэсний хөтөлбөр, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн зорилгод хувь нэмэр оруулахуйц буюу эсвэл тэдгээрт нийцсэн байна</b>		
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b>	<b>Олон улсын санхүүгийн Корпорацийн холбогдох үйл ажиллагааны стандарт, зорилго, шаардлагууд</b>	<b>Монгол орны СНСЗ-уудын элемент болон ОУСК-ийн ҮАС хоорондын нийцэж байгаа байдал</b>
A1. REDD+ Бодлого, арга хэмжээнүүд нь (БАХ) Байгаль орчныг хамгаалах талаар олон улсын хэмжээнд хүлээсэн үүрэг амлалтуудад нийцсэн, үндэсний хэмжээнд мөрдөж байгаа биологийн олон янз байдлыг хамгаалах бодлогод хувь нэмэр оруулна. Үүнд: РАМСАРЫН Конвенц, Ус хамгаалах үндэсний хөтөлбөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах Конвенц, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенц, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Ойн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хууль бус мод бэлтгэлтэй	ҮАС 6 (“Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент”), Удирдамж 6 (GN1 ба GN24).	“Экосистемийн үйлчилгээний менежмент” гэснээс бусад нь нийцэж байна (ҮАС 6, 24-25 дахь хэсэг). Экосистемийн үйлчилгээг хамгаалах төлбөртэй холбоотой БХЖ хараахан гараагүй байна.



тэмцэх тухай Санкт Петербургийн тунхаг.		
A2. REDD+-ийн БАХ-нүүдийг нь Төрөөс ойн талаар баримтлах бодлого, Ойн тухай хууль, Ойн цэвэрлэгээ хөтөлбөр, Ногоон хөгжлийн бодлого болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой бодлогод нийцсэн байна.	ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), Зорилго (d) “Байгаль орчин хамгаалах хэрэгцээ болон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг уялдуулах нь”	Нийцэж байна.
A3. REDD+-ийн БАХ-нүүд нь МУ-ын Засгийн газраас ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийн дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн хэтийн төлөв 2030, дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн байна.	ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа эмзэг бүлгийн хүн амд сөрөг нөлөө учруулж болзошгүй төслүүдэд илүү хамаатай.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулиар хоорондоо нийцэж байна.
A4. REDD+ БАХ-нүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт, хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүд болох Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, НҮБУАӨСК-д оруулах Үндэсний зорилтот хувь нэмэрт тусгагдсан холбогдох зорилго/ зорилттой нийцсэн байна.	ҮАС 3 (Нөөцийн үр ашиг болон бохирдлоос сэргийлэх), ялангуяа хүлэмжийн хийг бууруулах тухай Шаардлага (7-8 хэсэг), болон ХХЯ-ыг тоолохтой холбоотой (Удирдамж 3, хавсралт А) шаардлагууд	Зарим талаараа нийцэж байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)-ийн хүрээнд дагалдаж гарсан нөлөөлөх байдлын үнэлгээний журманд жилд 25000 тонноос илүү хэмжээтэй CO <sub>2</sub> ялгаруулж байгаа байгууллагууд хүлэмжийн хийн тооллого хийх ёстой гэсэн шаардлага тавьдаг.
A5. REDD+ БАХ-нүүд нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаг, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн тухай Конвенц болон Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого зэрэг хүний эрх, иргэдийн амьжиргааг дэмжих талаар хүлээсэн үүрэг амлалт, бодлогод нийцсэн байна.	<p>ҮАС 2 (Хөдөлмөр эрхлэх, ажиллах нөхцөл), ялангуяа зорилго (a): “Ижил тэгш хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, ижил боломж олгох”, Зорилго (c): “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үндэсний хэмжээнд мөрдөж байгаа хууль, тогтоомжуудтай нийцсэн байх”</p> <p>ҮАС 4 (Олон нийтийн эрүүл мэнд, эрүүл ахуй, аюулгүй байдал), ялангуяа зорилго (b): “хүний амь нас ба эд хөрөнгийг хүний эрхийн холбогдох</p>	Нийцэж байна. Ажлын байрны эрүүл ахуй болон аюулгүй байдлын асуудлуудыг E5-д тусгасан.

	зарчимд нийцүүлэн хамгаалах”.	
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим В: Хууль эрхзүй, бие даасан байдлыг харгалзан үзсэн ил тод, үр дүнтэй үндэсний ойн засаглалын бүтэцтэй байх</b>		
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b>	<b>Олон улсын санхүүгийн Корпорацийн холбогдох үйл ажиллагааны стандарт, зорилго, шаардлагууд</b>	<b>Монгол орны СНСЗ-уудын элемент болон ОУСК-ийн ҮАС хоорондын хэр нийцэж байгаа байдал</b>
В1. REDD+ БАХ-нүүдийг Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох БХЖ-ийн заалтуудад нийцүүлэн хэрэгжүүлж, хяналт тавина. REDD+ Үндэсний Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд нэг удаа талуудын оролцоотойгоор хянана.	ҮАС 1 (Байгаль орчны эрсдэл үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа зорилго (а): “Санхүүжилт шаардлагатай төслийн саналыг нягталж эрсдэл, үр ашгийг тодорхойлно”.	Нийцсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан байгаль орчны үнэлгээний туршлага нь олон улсын хэмжээнд тэргүүн туршлага болж хэрэгжиж байгаа. Ойн чиглэлийн төслүүдэд үнэлгээ хийх .
В2. REDD+-ийн БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ шаардлагатай боловсон хүчин, техникийн нөөцийг хуваарилж, Ойн тухай хуулийн хүрээнд боловсруулсан ойн тогтвортой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой институци болон техникийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг багтаасан байна.	--	ҮАС-ийн хүрээнд хамаарахгүй.
В3. Үндэсний REDD+-ийн БАХ-нүүд нь зөрчил, авлигын эрсдэлийг бууруулах, мөн ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлыг хариуцсан талуудын үүрэг, хариуцлагыг холбогдох БХЖ (Монгол Улсын Авлигатай тэмцэх хууль, Төсвийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль)-уудад заасны дагуу тодорхойлж, тэдгээр хууль, тогтоомжийг мөрдөнө.	Авлига болон хариуцлагын талаар заасан тусгай ҮАС байхгүй. Зарим нь ҮАС 2 (“хөдөлмөр эрхлэх, ажиллах нөхцөл”)-той холбоотой байхын зэрэгцээ, ялангуяа “үндэсний хэмжээнд мөрдөж байгаа хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцсэн байх” гэсэн зорилго (с)-тэй уялдаж байна.	Зарим талаараа нийцэж байна.
В4. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж хэрэгжүүлэхдээ ил тод, үр дүнтэй ойн сайн	Салбар дундын уялдаа холбоог хангахтай холбоотой ҮАС байхгүй.	ҮАС-д хамаарахгүй.

засаглалыг дэмжихэд чиглэсэн үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа бодлого, зохицуулалтууд, холбогдох хэрэгжүүлэгч байгууллагууд салбар хоорондын уялдаа холбоог хангасан байна.		
B5. REDD+ БАХ-ын боловсруулж хэрэгжүүлэхдээ жендерийн тэгш байдлыг дэмжих, Жендерийн тэгш байдлыг дэмжих тухай хуулийн шаардлагыг хангасан байна.	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр жендерийн чиглэлээр гарах үр нөлөөний талаарх (4-р хэсэг) заалттай холбоотой байна.</p> <p>ҮАС 2 (Хөдөлмөр эрхлэх, ажиллах нөхцөл), ялангуяа зорилго (а): “тэгш хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, адил тэгш боломж олгох”-той нийцэж байна.</p>	Нийцэж байгаа, ялангуяа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны салбарын жендерийн стратеги гэсэн хуулиудтай.
B6. REDD+ БАХ-г Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтуудтай нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх ба БАХ-нүүдийн талаарх мэдээлэл ил тод, хүртээмжтэй байж, холбогдох талуудад мэдээллийг тохирох аргаар хүргэнэ.	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа “Мэдээллийг нээлттэй байлгах” (29-р хэсэг), болон “Олон нийттэй харилцах, гомдол барагдуулах механизм”-ын талаарх шаардлагатай нийцсэн байна (34-35 хэсэг).</p> <p>Мэдээллийн хүртээмжтэй холбоотой бодлого (2012).</p>	Нийцэж байна.
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим С - Олон улсын өмнө хүлээсэн үүрэг, үндэсний нөхцөл байдал, хууль тогтоомж, мөн НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн баталсан Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ийн Тунхагийг харгалзан үзэж, уугуул иргэдийн болон орон нутгийн нөхөрлөлийн гишүүдийн мэдлэг, эрхийг хүндэтгэх</b>		
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b>	<b>Олон улсын санхүүгийн Корпорацийн холбогдох үйл ажиллагааны стандарт, зорилго, шаардлагууд</b>	<b>Монгол орны СНСЗ-уудын элемент болон ОУСК-ийн ҮАС хоорондын хэр нийцэж байгаа байдал</b>
C1. REDD+-ийг хэрэгжүүлэхдээ нутгийн иргэд болон угсаатны цөөнх гэдгийг холбогдох БХЖ-д зааснаар тодорхойлж авч үзэх ба байгалийн нөөцийг бие даан	ҮАС 7 (Уугуул иргэд), ялангуяа зорилго (а): “уугуул иргэдийг бүх талаар хүндэтгэх”	Нийцэхгүй байна. Уугуул иргэдийг тодорхойлсон БХЖ одоогоор байхгүй.

<p>захирах эрхийг хамруулж ойлгоно.</p>		
<p>С2. REDD+ БАХ-нүүд нь нүүрстөрөгчийг бууруулснаас ирэх үр өгөөж болон экосистемийн үйлчилгээг сайжруулсантай холбоотой үр ашгийг зохих ёсоор, тэгш хүртээх зарчмаар хэрэгжиж, REDD+-ийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. REDD+ БАХ-нүүдийн хүрээнд урамшуулах, үр ашгийг хуваарилахад одоогийн хэрэгжиж байгаа журам, бүтцийг (нөхөрлөл, орон нутгийг хөгжүүлэх сан г.м) ашиглана.</p>	<p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа “Экосистемийн үйлчилгээний менежмент” –тэй холбоотой шаардлага (24-25 хэсэг), “Байгалийн нөөцийн тогтвортой менежмент” (26-29 хэсэг), зорилго (d): “Байгаль хамгаалах хэрэгцээг хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах нь”</p> <p>ҮАС 8 (Соёлын өв), ялангуяа зорилго (b): “Соёлын өвтэй холбоотой үр ашгийг тэгш хувиарлах явдлыг дэмжих”, тавигдах шаардлага: “Төслийн үйл ажиллагаанд соёлын өвийг ашиглах” (16 хэсэг).</p> <p>ҮАС 7 (Уугуул иргэд), ялангуяа зорилго (c): “Тогтвортой бөгөөд соёлын онцлогт нийцсэн хөгжил, түүний үр ашиг, боломжийг бий болгох”, болон “Сөрөг нөлөөг бууруулах үйл ажиллагаа явуулсантай холбоотой гарах үр дүн”-г бууруулах шаардлага (18-20 хэсэг).</p>	<p>Зарим талаараа нийцэж байна. Ойн тухай хуульд заасанчлан ОН-үүдийн менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулж үр ашгийг хуваариладаг.</p> <p>Экосистемийн үйлчилгээний төлбөр, ба түүнийг хамгаалахтай холбоотой тодорхой БХЖ одоогоор байхгүй байна.</p>
<p>С3. REDD+-ийг боловсруулах, хэрэгжүүлэхдээ оролцогч талуудын газар болон байгалийн нөөц ашиглах эрхийг нь зохицуулсан БХЖ-уудтай нийцүүлнэ. Мөн REDD+-ийн БАХ-нүүд нь Газрын тухай хуулиар зохицуулагдах харилцааг илүү ойлгомжтой бөгөөд тодорхой болгож өгсөн байна.</p>	<p>ҮАС 5 (Газар эзэмших, албадан нүүлгэн шилжүүлэх), ялангуяа зорилго (a): “Газрыг хураан авах болон газар ашиглалтыг хязгаарласантай холбогдон үүсэж болох нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаварыг бууруулах буюу зайлсхийх”.</p>	<p>Нийцэж байна.</p>

<p>C4. REDD+ БАХ-нүүдийг нутгийн иргэд эсвэл үндэстний цөөнхийн эзэмшлийн уламжлалт мэдлэг, өв соёл болон оюуны мэдлэг, хөрөнгийг хамгаалах буюу дэмжихэд чиглэсэн холбогдох БХЖ-уудын (Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль) зүйл, заалтуудтай нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ. Нутгийн иргэдийн эзэмшлийн соёлын биет өвийг төр, шашны болон олон нийтийн байгууллагаас тогтоосон нөхцөлийн дагуу хамгаална.</p>	<p>ҮАС 8 (Соёлын өв), ялангуяа зорилго (а): “Соёлын өвийг хамгаалах, хадгалах”, тавигдах шаардлага: “Соёлын чухал өвтэй холбоотой асуудлаар урьдчилан чөлөөтэй мэдээлж зөвшилцөх шаардлагатай нөхцөл” (16-17 хэсэг).</p>	<p>ҮАС 8-д заасан чөлөөтэй урьдчилан мэдээлэх талаарх онцгойлсон заалтаас бусад нь нийцэж байгаа.</p>
<p>C5. Үндэсний REDD+-ийн БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ тухайн газар болон байгалийн нөөцийг эзэмших эрхтэй иргэдийг нүүлгэн суурьшуулах болон/эсвэл эдийн засгийн үйл ажиллагааны зорилгоор нүүлгэх шаардлагатай болсонтой холбоотой үүсэх аливаа эрсдэлээс зайлсхийсэн буюу эрсдэлийн бууруулахад анхаарсан байна. REDD+ БАХ-г хэрэгжүүлэхээс өмнө нутгийн иргэдийг албан шахалтаар нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд зохих хэлбэрийн нөхөн төлбөрийг санал болгож, зөвшилцсөн байна.</p>	<p>ҮАС 5 (Газар эзэмших, албадан нүүлгэн шилжүүлэх), ялангуяа зорилго (а): “Газрыг хураан авах болон газар ашиглалтыг хязгаарласантай холбогдон үүсэж болох нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах буюу зайлсхийх”, мөн “Нүүлгэн шилжүүлсэн иргэдэд нөхөн төлбөр олгох” тухай шаардлага (9-р хэсэг)</p>	<p>Нийцэж байна.</p>
<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим D - Оролцогч талууд, тухайлбал, нутгийн иргэд, орон нутгийн иргэдийн бүрэн бөгөөд үр дүнтэй оролцоог хангах; [REDD+-ийн үйл ажиллагаануудад]</b></p>		
<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b></p>	<p><b>Олон улсын санхүүгийн Корпорацийн холбогдох үйл ажиллагааны стандарт, зорилго, шаардлагууд</b></p>	<p><b>Монгол орны СНСЗ-уудын элемент болон ОУСК-ийн ҮАС хоорондын хэр нийцэж байгаа байдал</b></p>
<p>D1. REDD+-ийн БАХ-нүүдийг боловсруулах ба хэрэгжүүлэх явцад холбогдох оролцогч талуудыг тодорхойлсон байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа “Дүн шинжилгээ, ба</p>	<p>Нийцэж байна. Ялангуяа БАХ-үүд нь БОНБУ-ийн тухай хуулийн дагуу хэрэгжих бол энэ заалт хоорондоо нийцнэ.</p>

<p>Тухайн БАХ-нээс хамаараад оролцогч талууд гэдэгт орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, ТХНЗ, усны сав газар, нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллага, холбоо, малчид, аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн бусад байгууллагыг хамруулна. Тухайн төлөөлөгч оролцогч талууд нь зохих ёсны төлөөлөл байж чадах эсэхийг холбогдох хууль, журмын дагуу тогтооно.</p>	<p>талуудын оролцоог хангах төлөвлөгөө” (26-32 хэсэг).</p> <p>ҮАС 5 (Газрыг хураан авах, албадан нүүлгэн шилжүүлэх), ялангуяа “олон нийтийн оролцоо”-той холбоотой шаардлага (10-р хэсэг)</p> <p>ҮАС 7 (Уугуул иргэд), ялангуяа “Оролцоо ба зөвшилцөл” –тэй холбоотой шаардлага (Хэсэг 10-12).</p>	<p>Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд мөн талуудыг тодорхойлох, тэдний оролцоог хангахыг дэмжсэн байдаг.</p>
<p>D2. REDD+ БАХ-нүүдийг тодорхойлох болон хэрэгжүүлэх явцад холбогдох оролцогч талууд нь санал болгож буй БАХ-нүүдийн талаар мэдээлэл авах, зөвлөлдөх, шийдвэр гаргахад оролцох эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, холбогдох хууль журмын дагуу хэрэгжүүлнэ. REDD+-ийн төлөвлөгөө болон хэрэгжилттэй холбоотой шийдвэр нь гаргах үйл явц нь: (i) холбогдох нотолгоо, мэдлэгт суурилсан; (ii) төр, иргэний нийгэм, олон нийт болон бусад талуудын нээлттэй хэлэлцүүлэгт үндэслэсэн; (iii) дээрх талуудын өгсөн саналыг харгалзсан байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа “Дүн шинжилгээ, ба талуудын оролцоог хангах төлөвлөгөө”-тэй холбоотой шаардлага (Хэсэг 26-32).</p> <p>ҮАС 5 (Газрыг хураан авах, албадан нүүлгэн шилжүүлэх), ялангуяа “олон нийтийн оролцоо”-той холбоотой шаардлага (10 хэсэг)</p> <p>ҮАС 7 (Уугуул иргэд), ялангуяа “Оролцоо ба зөвшилцөл”-тэй холбоотой шаардлага (Хэсэг 10-12).</p>	<p>Нийцэж байна. Ялангуяа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн олон нийтийн оролцоо (Бүлэг 4)-той холбоотой заалттай нийцэж байна.</p>
<p>D3. REDD+-ийн БАХ-нүүдийг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ холбогдох үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй уялдуулсан байх ба салбар дундын болон олон талын хамтын ажиллагааны механизмуудыг ашиглан REDD+БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлж хяналт тавина.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа “Сөрөг нөлөөлөлд өртсөн иргэдийн талаар тогтмол мэдээлж байх”-тай холбоотой шаардлага (36-р хэсэг).</p>	<p>Нийцэж байна.</p>
<p>D4. МУ-ын Засгийн газар нь REDD+ийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийн улмаас эрх нь зөрчигдсөн гэх иргэд болон талуудад холбогдох БХЖ-ын дагуу санал гомдлоо шийдвэрлүүлэх эрхийг нь хангаж,</p>	<p>ҮАС 5 (Газрыг хураан авах, албадан нүүлгэн шилжүүлэх), ялангуяа “гомдол барагдуулах механизм”-тай холбоотой шаардлага (11-р хэсэг)</p>	<p>Нийцэж байгаа, REDD+-ийн гомдол барагдуулах механизмыг боловсруулах гэж байна.</p>

<p>гомдол, санал барагдуулах зохистой, ил тод механизмыг бүрдүүлж өгсөн байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент), ялангуяа “Олон нийттэй харилцах, гомдол барагдуулах механизм”-тай холбоотой шаардлага (Хэсэг 34-35).</p> <p>ҮАС 2 (Хөдөлмөр эрхлэх, ажиллах нөхцөл), ялангуяа зорилго (b) буюу “гомдол барагдуулах механизм”-тай холбоотой шаардлага.</p>	
<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Зарчим Е - Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим Е: Тэдгээр үйл ажиллагаа нь байгалийн ой, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудалтай нийцсэн байх ба [REDD+] үйл ажиллагааг байгалийн ойг хувиргахад ашиглах бус харин байгалийн ой болон түүнийг экосистемийн үйлчилгээг хамгаалахад чиглэсэн урамшуулал бий болгох, мөн нийгэм, байгаль орчны бусад үр ашгийг сайжруулахад ашигладаг байх.</b></p>		
<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b></p>	<p><b>Олон улсын санхүүгийн Корпорацийн холбогдох үйл ажиллагааны стандарт, зорилго, шаардлагууд</b></p>	<p><b>Монгол орны СНСЗ-уудын элемент болон ОУСК-ийн ҮАС хоорондын хэр нийцэж байгаа байдал</b></p>
<p>E1. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойн талаарх улсын хэмжээнд мөрдөж байгаа албан ёсны тодорхойлолтод суурилсан, түүнд нийцсэн байна.</p>	<p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа (a) зорилгын “хувиргасан амьдрах орчин” (хэсэг 11-15); “гол амьдрах орчин” (Хэсэг 16-19), “Тусгай хамгаалалттай газар” (20-р хэсэг)-тэй холбоотой шаардлага</p>	<p>Зарим талаараа нийцэж байна. ҮАС6 нь байгалийн ойгоос илүүтэй байгалийн амьдрах орчинтой илүү холбоотой юм. Монгол улсад “байгалийн ой”-н талаарх тодорхойлолтыг нэгдсэн байдлаар тодорхойлж, санал нэгдээгүй байна.</p>
<p>E2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ ойн сан бүхий болон ойгоос бусад газар нутгийн аль алинд нь учрах нөлөөллийг үнэлэхтэй холбоотой хууль эрх зүйн шаардлагыг бүрэн хангасан байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент).</p>	<p>Нийцсэн. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан байгаль орчны үнэлгээний туршлага олон улсын хэмжээнд тэргүүн туршлага болж хэрэгжиж байгаа. Ойн чиглэлийн төслүүдэд үнэлгээ хийнэ.</p>
<p>E3. REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойг хамгаалах, хадгалах явдлыг урамшуулах, ой ашиглагчдын хариуцлагыг</p>	<p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа (a)</p>	<p>Зарим талаараа нийцэж байна. Ойн тухай хуульд заасанчлан ОН-үүдийн менежментийн</p>

<p>дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг илүү сонгон хэрэгжүүлж, байгалийн ойг доройтуулахаас зайлсхийх буюу эрсдлийг бууруулна.</p>	<p>зорилго буюу “Биологийн төрөл зүйлийг хамгаалах”-тай холбоотой “хувиргасан амьдрах орчин” (хэсэг 11-15); “гол чухал амьдрах орчин” (хэсэг 16-19); “тусгай хамгаалалттай газар нутаг” (20-р хэсэг) зэрэг шаардлагууд</p> <p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа зорилго (b) буюу “экоциемийн үйлчилгээний үр ашгийг тогтвортой байлгах”-тай холбоотой шаардлага</p> <p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа зорилго (c) буюу “Байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих”-тэй холбоотой шаардлага</p> <p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа зорилго (d) буюу “Байгаль хамгаалах хэрэгцээг хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах нь”-тай холбоотой шаардлага</p> <p>ҮАС 7 (Уугуул иргэд), ялангуяа зорилго (c) буюу “Тогтвортой бөгөөд соёлын онцлогт тохирсон орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагаанаас гарах үр ашиг ба боломж”-тай холбоотой шаардлага</p>	<p>төлөвлөгөөгөөр дамжуулж үр ашгийг хуваарилдаг.</p> <p>“Экосистемийн үйлчилгээний менежментийн” (ҮАС 6-ийн 24-25 дахь хэсэг) талаар одоогоор экосистемийн үйлчилгээний төлбөр, түүнийг хамгаалахад чиглэсэн тодорхой БХЖ одоогоор байхгүй байна.</p>
<p>E4. REDD+-ийн БАХ-нүүдийг байгалийн ойг таримал ой болгон хувиргах, ийнхүү хувиргахыг дэмжихэд ашиглахгүй байх</p>	<p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент)-ийн “гол чухал амьдрах орчин” (хэсэг 16-19)-той холбоотой шаардлага</p>	<p>Зарим талаараа нийцэж байгаа. Байгалийн ой болон унаган төрхөөрөө байгаа амьдрах орчны талаарх нэр томъёотой холбоотой дээр байгаа саналыг үзнэ үү.</p>



<p>E5. REDD+-ийн үйл ажиллагааг боловсруулах, эрэмбэлж, хэрэгжүүлэхдээ нийгмийн сөрөг нөлөө учруулахаас зайлсхийж, эдийн засаг, нийгмийн сайн сайхан байдал, үр ашгийг дэмжиж, ялангуяа эмзэг бүлгийн хүмүүст ажил эрхлэх боломжийг нь нэмэгдүүлэх талаар онцгой анхаарал хандуулна.</p>	<p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа зорилго (b) буюу “экоситемийн үйлчилгээний үр ашгийг тогтвортой байлгах”-тай холбоотой шаардлага</p> <p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа зорилго (c) буюу “Байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих”-тэй холбоотой шаардлага</p> <p>ҮАС 4 (нутгийн иргэдийн эрүүл мэнд, эрүүл ахуй, аюулгүй байдал), Зорилго (b) буюу “хувь хүн болон эд хөрөнгийг холбогдох хүний эрхийн зарчмуудад нийцүүлэн хамгаалах”-тай холбоотой шаардлага</p>	<p>Нийцэж байгаа.</p>
<p>E6. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ оролцогч талуудтай орон нутгийн болон үндэсний хэмжээнд зөвлөлдсөний үндсэн дээр хамгаалалтын ач холбогдол өндөртэй ойг тодорхойлж, тэдгээрийн экосистемийн үйлчилгээг хамгаалах, нөхөн сэргээхэд тусална.</p>	<p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент)-ийн онцгойлон “гол чухал амьдрах орчин” (хэсэг 16-19)-той холбоотой шаардлага</p>	<p>Нийцсэн гэхдээ экосистемийн үйлчилгээний төлбөр, хамгаалалтын ач холбогдол өндөртэй ойн талаарх БХЖ, зохицуулалт байхгүй.</p>
<p><b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим F:- Үр дүн хувирах эрсдлийг тооцох</b></p>		
<p>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</p>	<p>Олон улсын санхүүгийн Корпорацийн холбогдох үйл ажиллагааны стандарт, зорилго, шаардлагууд</p>	<p><b>Монгол орны СНСЗ-уудын элемент болон ОУСК-ийн ҮАС хоорондын хэр нийцэж байгаа байдал</b></p>
<p>F1. REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох болон хэрэгжүүлж, хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн</p>	<p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа (a) зорилгын “хувиргасан амьдрах орчин” (хэсэг 11-15); “гол</p>	<p>Ойн хомсдол, доройтлын хүчин зүйлсийг БАХ-үүдийн хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар</p>

<p>үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+-ийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна.</p>	<p>амьдрах орчин ” (Хэсэг 16-19), “Тусгай хамгаалалттай газар” (20-р хэсэг)-тэй холбоотой</p> <p>ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент)-ийн зорилго (с) буюу “Байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих”-тэй холбоотой</p>	<p>зохицуулахаар бол нийцэж байна.</p>
<p>F2. REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөж болох эрсдэлүүдийг харгалзаж үзсэн байна. Эдгээр эрсдэлд (хуулийн, нийгэм, экологийн хүчин зүйлс буюу бодлого өөрчлөгдөж, ойн нөөцийн хэт ашиглалт нэмэгдэх г.м) дүн шинжилгээ хийсний үндсэн дээр, REDD+ БАХ-нүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхдээ үр дүн хувирах эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгасан байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент).</p>	<p>Хэрэв үр дүн хувирах эрсдэлийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль болон бусад холбогдох БХЖ-уудаар зохицуулахаар бол нийцнэ.</p>
<p>F3. Үндэсний ойн мониторингийн систем (YOMC)-ийг боловсруулж, сайжруулан, ашиглахдаа хөтөлбөрийн үр дүн хувирч, өөрчлөгдөж байгаа талаар болон өмнө тодорхойлсон эрсдэлүүдтэй холбоотой мэдээллийг илрүүлэх давтамж, тохиргоог хийж өгсөн байна. Үүнийг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон техникийн чадавхыг бүрдүүлнэ.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент)-ийн “Сөрөг нөлөөлөлд өртсөн иргэдийн талаар тогтмол мэдээлж байх” (36-р хэсэг)-тай холбоотой шаардлага.</p>	<p>БОНБУ-ний тухай хуулиар төслийг батлахдаа, төслийн үйл ажиллагааны талаар мэдээ тайлан өгч байх тухай шаардлага тусгасан байдаг. Үүнээс өөрөөр үйл ажиллагааны стандарттай шууд нийцэхгүй байна.</p>
<p>F4. Аливаа үр дүн хувирч, эсрэгээр өөрчлөгдөх тохиолдол гарсан үед түүний шалтгааныг судалж, зохих менежментийн арга хэмжээ авч байх механизмыг REDD+-ийн хяналт, үнэлгээний системд суулгаж өгсөн байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент)</p>	<p>БОНБУ-ний тухай хуулиар төслийг батлахдаа, төслийн үйл ажиллагааны талаар мэдээ тайлан өгч байх тухай шаардлага тусгасан байдаг. Үүнээс өөрөөр үйл ажиллагааны</p>

		стандарттай шууд нийцэхгүй байна.
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим G: Хүлэмжийн хийн ялгаралт өөр газар шилжих явдлыг бууруулах</b>		
<b>Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмыг үндэсний нөхцөлд тодорхойлсон элемент</b>	<b>Олон улсын санхүүгийн Корпорацийн холбогдох үйл ажиллагааны стандарт, зорилго, шаардлагууд</b>	<b>Монгол орны СНСЗ-уудын элемент болон ОУСК-ийн ҮАС хоорондын хэр нийцэж байгаа байдал</b>
G1. Монгол орны REDD+ Хөтөлбөр болон үүний гол хэсэг болох REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа улсын нийт нутаг дэвсгэрийг аль болох зохих ёсоор хамруулах (ойн болон холбогдох ой бус экосистемүүдийг оруулах г.м) ба REDD+-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах шаардлагатай өөр өөр салбарын талуудын оролцоог багтаасан байна.	ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент)-ийн зорилго (с) буюу "Байгалийн амьд нөөцийн тогтвортой менежментийг дэмжих"-гэй холбоотой шаардлага  ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент)-ийн зорилго (d) буюу "Байгаль хамгаалах хэрэгцээг хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулах"-гай холбоотой шаардлага	Нийцэж байгаа.
G2. REDD+-ийн үйл ажиллагааг төлөвлөх, сонгох, хэрэгжүүлэх болон хяналт тавихдаа ойн хомсдол, доройтолд хүргэж буй голлох шууд болон дам хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг хамруулахын зэрэгцээ REDD+-ийг Монгол Улсад тогтвортой хэрэгжүүлэхэд гол тулгуур болох ойн тогтвортой менежмент, хамгааллын үйл ажиллагааг орон нутгийн болон улсын хэмжээнд сайжруулахад саад болж буй бэрхшээлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг ойн салбарын холбогдох БХЖ-ын дагуу тусгасан байна.	ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент), ялангуяа (a) зорилгын "хувиргасан амьдрах орчин" (хэсэг 11-15); "гол амьдрах орчин" (Хэсэг 16-19), "Тусгай хамгаалалттай газар" (20-р хэсэг)-гэй холбоотой  ҮАС 6 (Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн нөөцийн тогтвортой менежмент)-ийн онцгойлон зорилго (с) буюу "Байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих"-гэй холбоотой шаардлага	Ойн хомсдол, доройтлын хүчин зүйлсийг БАХ-нүүдийн хүрээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулахаар бол нийцэж байна.

<p>G3. REDD+ БАХ-нүүдийг боловсруулахдаа тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэний улмаас сөрөг нөлөө нь ойн болон ойн бус өөр газарт шилжих эрсдэл үүсч, ой түшиглэж амьдардаг болон бусад төрлийн аж ахуй эрхэлдэг иргэдийн амьжиргаанд нөлөөлөх эрсдэл үүсч болохыг харгалзан үзсэн байна. Эдгээр эрсдлийг шинжилж үзсэний үндсэн дээр тэдгээрийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг БАХ-нүүдэд тусгасан байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент).</p> <p>ҮАС 5 (Газар эзэмших, албадан нүүлгэн шилжүүлэх), ялангуяа зорилго (а): “Газрыг хураан авах болон газар ашиглалтыг хязгаарласантай холбогдон үүсэж болох нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаварыг бууруулах буюу зайлсхийх”, мөн “Нүүлгэн шилжүүлсэн иргэдэд нөхөн төлбөр олгох” тухай шаардлага (9-р хэсэг)</p>	<p>Хэрэв үр дүн шилжих эрсдлийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль болон бусад холбогдох БХЖ-уудаар зохицуулахаар бол нийцнэ.</p>
<p>G4. Үндэсний ойн мониторингийн системд хүлэмжийн хийн ялгаралт өөр газарт шилжиж байгаа талаарх мэдээллийг илрүүлж, мэдээлэл өгч байх давтамжийг тохируулж өгсөн байх ба үүнийг гүйцэтгэхэд шаардагдах боловсон хүчний болон техникийн нөөцийг шийдэж өгсөн байна.</p>		<p>БОНБУ-ний тухай хуулиар төслийг батлахдаа, төслийн үйл ажиллагааны талаар мэдээ тайлан өгч байх тухай шаардлага тусгасан байдаг. Үүнээс өөрөөр үйл ажиллагааны стандарттай шууд нийцэхгүй байна.</p>
<p>G5. REDD+-ийн үйл ажиллагааг хянах, үнэлэх системд хүлэмжийн хийн ялгаралт ой, ойн бус өөр газарт шилжсэн тохиолдолд үүний цаад шалтгааныг олж тогтоон, зохих менежментийн арга хэмжээг авч байх механизмыг суулгаж өгсөн байна.</p>	<p>ҮАС 1 (Байгаль орчин нийгмийн эрсдэл, үр нөлөөний үнэлгээ ба менежмент)</p>	<p>БОНБУ-ний тухай хуулиар төслийг батлахдаа, төслийн үйл ажиллагааны талаар мэдээ тайлан өгч байх тухай шаардлага тусгасан байдаг. Үүнээс өөрөөр үйл ажиллагааны стандарттай шууд нийцэхгүй байна.</p>



<http://www.reddplus.mn>



**REDD+in  
Mongolia**



**REDD+ in  
Mongolia**



**REDD+ in  
Mongolia**